



## **ЛАМЖАВЫН МИЖИДДОРЖ**

*/Улаанбаатар хотын захиргааны дарга/  
/1929-1930 он/*

Засагт хан аймаг, Нөмрөг уулын хошуу, одоогийн Завхан аймгийн Нөмрөг сумын нутагт 1902 онд төрсөн. Гэрийн сургуулиар бичиг үсэгт суралцаж, 1922, 1924 онд МХЗЭ, МАХН-д гишүүнээр элссэн. 1922 оноос Завхан аймгийн захиргаанд бичээч, намын хорооны тэргүүлэгч, суртлын эрхлэгчээр ажиллаж байжээ.

Л.Мижиддорж нь 1929 оны 8 дугаар сарын 13-нд Засгийн газрын эрхлэгч товчооны 8 дугаар тогтоолын дөрөвдүгээр зүйлээр Улаанбаатар хотын захиргааны даргаар томилогдож, 1929 оны 12 дугаар сард хуралдсан хотын захиргааны 7 дугаар их хуралд хотын захиргаанаас нэг жилийн хугацаанд хийсэн ажлын тайланг тавьж хэлэлцүүлсэн байна.

Хотын захиргааны дарга байхдаа 1930 оны эхээр баруун аймагт гарсан “Төгс буянт”-ын бослогыг дарах ажлыг хариуцан Б.Элдэв-Очир даргатай Засгийн газрын комиссын бүрэлдэхүүнд оролцож чухал үүрэг гүйцэтгэсэн, мөн 1929 оны наймдугаар сараас 1930 оны 3 дугаар сар хүртэл Солонгосын ард түмний эрх чөлөөний төлөө тэмцэгч Хим-Цо-Бай гэдэг хүнийг өөрийн гэртээ хамгаалалтад авч тал бүрийн туслалцаа үзүүлж байсан зэрэг түүний

шударга үйл ажиллагаа, хүмүүнлэг сайн чанарыг тэр үед Мижиддоржтой нэгэн гэрт хэсэг хугацаанд хамт амьдарч байсан Ардын хувьсгалын партизан П.Нямхүү гуай дурсан ярьжээ.

Л.Мижиддорж “МАХН-ын 10 жилийн ойг тэмдэглэх нь” гэсэн өгүүлэл бичиж нийтлүүлсэн нь "Үнэн" сонины 1931 оны 3 дугаар сарын нэгний дугаарт үлджээ.

1930 оны эхээр Хотын захиргааны даргын үүрэгт ажлаас чөлөөлөгдөж Ардыг гэгээрүүлэх яамны орлогч сайдаар ажиллаж байгаад 1931 онд ЗСБНХУ-д /КУТВ-т/ гэргий Дуламсүрэнгийн хамт суралцахаар явж нэг жил орчим суралцаад, нүдний хараа муудаж нутагтаа буцаж ирээд эмчилгээ авахгүй бие нь муудсаар 1938 оны 12 дугаар сард нас баржээ.